

ЗҮҮН ХОЙТ АЗИЙН БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД МОНГОЛ УЛСЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ, ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Профессор НАСАН
Монгол судлаач БААТАР

Нэг.Зүүн хойт Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны хөгжлийн хандлага

1990-ээд онд, дэлхийн улс төр, эдийн засгийн байдалд асар их өөрчлөлт гарав. Цэргийн сөргөлдөөнөөс яриа хэлэлцээнд шилжиж, эдийн засгийн шинэ дэглэм бий болж, хөгжингүй орнуудын аж үйлдвэр гадагш хандан, бүсчилэх, бүлэглэх, интеграцчилах үйл явц дэлхийн эдийн засгийн гол хандлага болов. Энэхүү гол хандлагад зохицуулан, 1991 онд НҮБ-ийн Хөгжлийн газраас (UNTD) Түмэн голын бүс нутгийг хөгжүүлэх төлөвлөгөөг албан ёсоор баталж, 20 жилийн хугацаанд 30 тэрбум америк долларын хөрөнгө оруулан энэ бүс нутгийг Зүүн хойт Азийн (ЗХА) “Гонконг”, “Роттердам” болгохоор тогтсон юм. 1995 оны 12-р сард БНХАУ, ОХУ, БНАСАУ-ын төлөөлөгчид, мөн БНХАУ, ОХУ, БНАСАУ, БНСУ, Монгол улсын төлөөлөгчид Нью-Йорк дахь НҮБ-ийн хөгжлийн төвд Түмэн голын бүс нутгийг хөгжүүлэх тухай “Хоёр хэлэлцээр”, “нэг протокол”-д гарын үсэг зурж, Түмэн голын бүс нутгийн олон улсын хамтын ажиллагааны хууль эрхийн үндсийг тавьж түүнийгээ хэрэгжүүлэх ажилд орсон юм. Үүнээс хойш ЗХА-ийн бүс нутгийн олон улсын харилцаа мэдэгдэхүйц сайжирлаа. ЗХА-ийн бүс нутгийн олон улсын чанартай эдийн засаг, техникийн хамтын ажиллагаа түргэн хурдацтай хөгжиж байна. Үүнд:

- 1.Хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагаа түргэн хөгжиж байна.
- 2.Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа хэрэгжиж эхэллээ.
- 3.ЗХА-ийн орнууд хамтын ажиллагаагаа эрчимжүүлж, түүнийг цаашид улам ахиулах талаар нэгдсэн ойлголттой болов.

Бодитойгоор хэлбэл, БНХАУ 1995 оноос эхэлж хил хязгаарын нутагтаа эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлсний үндсэн дээр орчин үеийн аж үйлдвэрийн шинэ бүс нутгийн анхны төлөв бүрэлдэж, одоо энэ бүс нутагт 37 төсөл хэрэгжиж, 120 сая

-
- *.БНХАУ-ын ӨМӨЗО-ны Зүүн хойт Ази судлалын хүрээлэнгийн орлогч захирал .
 - *.Мөн хүрээлэнгийн судлах ажилтан

америк долларын хөрөнгө оруулалт хийгээд байна. Хятадын Хунчүнь дахь Хятад, Оросын хил худалдааны Чанлинзыгийн зах, Чюаньэр гол дахь Солонгос, Хятадын хил худалдааны захыг боловсронгуй болгож, Фанчуанд хил худалдааны зах нээх, улмаар татваргүй бүс болгохоор бэлтгэж байна.

ОХУ эдийн засгийн чөлөөт бүсийг Владивосток, Находка, Хасан гэсэн гурван газарт байгуулж, юуны өмнө Находкын эдийн засгийн бүсийг хөгжүүлж, 2000 оноос өмнө 5,4 тэрбум долларын хөрөнгө оруулахаар төлөвлөсөн юм. ОХУ-аас жил бүр Находкад 40 сая ам.долларын хөрөнгө оруулж байна.

1997 онд ОХУ, БНСУ хэлэлцэн тогтож, хоёр орны аж үйлдвэрийн шинэ бүсэд 700 сая ам.долларын хөрөнгө оруулахаар болов. ОХУ нь БНХАУ-ын Хунчүньтэй хиллэх Кураскинод олон улсын худалдааны хотхон байгуулж, “Түмэн голын эдийн засгийн чөлөөт бүсийн төсөл” боловсруулан, боомт, авто зам, төмөр зам байгуулах ажил хийж байна.

БНАСАУ ч гэсэн Түмэн голын бүс нутгийг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч, жил бүр 746 шоо км газар шорооны ажил хийж, Лужинь-Сяньфэн-гийн худалдааны чөлөөт бүс байгуулав. Түмэн голын бүс нутгийг хөгжүүлэх төлөвлөгөөг 2010 он хүртэл боловсруулж, үүнтэй холбогдуулан хэдэн арван хууль гаргав. Энэ бүс нутагт зориулж 1995 оноос эхэлж, жил бүр 50 сая ам.долларын хөрөнгө зарцуулж, дэд бүтцийг бий болгож байна. 1996 оны 9-р сард олон улсын эдийн засаг, худалдааны зөвлөлдөх хурлаас БНАСАУ-д 845 мянга 500 америк долларын хөрөнгө оруулалт бүхий 30 объект барихаар болсон юм. БНАСАУ 1997 оноос бүтээн байгуулалтын ажлаа түргэтгэж, нэлээд хэдэн төсөл хэрэгжүүлэн, чөлөөт эдийн засгийн бүсэнд зориулж 900 сая ам.долларын хөрөнгө оруулж, нийтдээ 2 тэрбум долларын хөрөнгө оруулахаар болсон юм.

Япон улс ч Түмэн голын бүс нутгийг хөгжүүлэхэд идэвхтэй оролцож байна. Японы үйлдвэр, худалдааныхан, улс төрчид Япон далайг тойрсон энэ бүс нутгийг хөгжүүлэхэд идэвхтэй оролцохоо илэрхийлсэн юм.

БНСУ нь энэ бүс нутагт хөрөнгө оруулалтаа эрс нэмэгдүүлж, үндэстэн дамнасан корпорацууд нь үүнд идэвхтэй оролцож байна. Тус улс Түмэн голын бүс нутагт авто зам, төмөр зам тавих далайн гарцыг бий болгоход ихээхэн анхаарч байна.

Монгол улс Түмэн голын бүс нутгийн олон улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны асуудлыг нэн хүндэтгэн үзэж, энэ бүс нутгийг хөгжүүлэхэд оролцох ажлын хэсгийг тусгайлан байгуулж, “ЗХА-ийн орнуудын Түмэн голын бүс нутгийн хамтын ажиллагааг нээн

хөгжүүлэх тухай төлөвлөгөө”-г батлан, дорнод бүс нутгийнхаа зам тээврийн барилга байгууламжийг чармайн сайжруулж байна. Тухайлбал, Төмөр зам тавих, Зүүн хойт Хятадын хилд хүрэх авто зам тавих бэлтгэлээ базааж, холбооны барилга байгууламжаа шинэтгэн, шинээр байгуулж, олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож байна. Монгол-Оросын, Монгол-Хятадын хил, Монгол-Хятад-Орос гурван улсын уулзварт эдийн засгийн чөлөөт бүс байгуулахаар төлөвлөж, ажлаа нэгэнт эхэлжээ. ОХУ-ын Сибирээс Монгол Улс, БНХАУ-ын нутгаар дамжин өнгөрөх байгалийн хий дамжуулах хоолой тавих олон талт хамтын ажиллагааг ажил хэрэг болгохоор холбогдох талууд зөвлөлдөж байгаа юм.

Товчоор хэлбэл, ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа ихээхэн хэтийн төлөвтэй юм. Холбогдох мэргэжилтнүүдийн тооцоолсноор, энэ бүс нутгийн хэтийн төлөв нь нэлээд урт хугацааны турш, хоёр талын хамтын ажиллагааг гол болгож, ЗХА-ийн бүс нутгийг нээлттэй болгох, харилцан ашигтай, тэгэхдээ эвсэл үл байгуулах эдийн засгийн хамтын ажиллагаа байх болно. Ийм хамтын ажиллагааны гол онцлог нь:

1. Бүс нутаг дахь улсуудын харилцааны тухайд, нийгмийн байгуулал, үзэл суртал, эдийн засгийн чиг баримжаа өөр өөр боловч хамтын ажиллагаагаа хөгжүүлэх боломж мэдэгдэхүйц нэмэгдэх болно. Энэ нь ЗХА-ийн бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хангаж, бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх урьдчилсан нөхцөл болох юм.

2. Эдийн засгийн дэг журмын тухайд, эрх тэгш, харилцан ашигтай байж, өрсөлдөхийн зэрэгцээ хамтаар оршиж, хамтаар хөгжих болно.

3. Олон улсын хөдөлмөрийн хуваарийн тухайд, өөр өөр хэлбэр маяг бүхий, доод шатнаас дээд шатанд хөгжих бүс нутгийн хөдөлмөрийн хуваарийн тогтолцоог аажмаар бий болгоно. Үүний гол хандлага нь харилцан нөхөж, хөнгөлөлттэй хуваарилалтаас эрх тэгш хуваарилалтанд шилжих явдал болно.

4. Олон улсын хамтын ажиллагааны дэг журмын тухайд, өөрийн улс, бүс нутагтаа бие даан, хил худалдаа хийж, дэд бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээг хөгжүүлэх явдлыг гол болгож, аажмаар бүх бүс нутгийн олон талт хамтын ажиллагаа болгох чиглэл баримтална. Мөн Европ, Америк, Ази тивийнхэн хамтран, хил худалдааны, бүс нутгийн, бүх бүс нутгийн, улмаар дэлхийн хамтын ажиллагааг хамарсан олон давхаргат, олон талт хамтын ажиллагааны хүрээ байгуулах болно.

5. Хамтын ажиллагааны явцын тухайд, иргэд хоорондын болон орон нутгийн харилцааг урьдал болгон, бүс нутаг дахь улсуудын засгийн газрын удирдлага, олон улсын зохицуулалтын дагуу сул дорой байгаа бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг нээлттэй, зохион байгуулалтанд оруулна.

Хоёр.Зүүн хойт Азийн эдийн засгийн бүс нутагт
Монгол Улсын эзлэх байр суурь, үзүүлэх нөлөө

Монгол Улс нь ЗХА-ийн бүс нутгийн буурай хөгжилтэй улс тул хөрөнгө мөнгө, техник, боловсон хүчин, удирдлага, дэд бүтцийн талаар бусад улсаас ихээхэн зөрөөтэй юм. Гэхдээ ЗХА-ийн эдийн засгийн хамтын ажиллагаанд Монгол Улс нь өөрийн гэсэн өвөрмөц давуу талтай юм. Үүнд:

1.Газарзүйн байрлалаараа Монгол Улс, Ази, Европыг холбосон давуу талтай. Өөрөөр хэлбэл, ЗХА-ийн улсуудыг Дундад Ази, Баруун Ази болон Европын улсуудтай холбох чухал гүүр болно.

Ази, Европыг холбосон энэ гүүрийг ашиглавал Монгол улсын хөгжилд төдийгүй, ЗХА-ийн бүс нутаг, улмаар дэлхийн эдийн засгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр болох юм.

2.Ашигт малтмалын давуу талтай. Тус улс өргөн уудам газар нутагтай, байгалийн болон газар доорхи баялаг ихтэй тул:

Хөдөө тал нь малаар дүүрэн

Хөрсөн доор нь эрдэнээр дүүрэн

Яндаж болдоггүй далай шиг

Яасан баян нутаг вэ гэж монголчууд дуулдаг.

Үнэхээр Монгол орон төрөл бүрийн ашигт малтмалаар баялаг цөөн улсуудын тоонд орох ба нүүрс, зэс, гянт болд, төмөр, хөнгөн цагаан, цагаан тугалга, молибден, алт, хайлуур, жонш, давс, шүү, фосфор, болор, эрдэнийн чулуу, үнэт чулуу, барилгын материалын ихээхэн нөөцтэй улс юм. Одоогийн байдлаар тус улсын илрүүлээд байгаа фосфор, зэс, гөлтгөнө зэрэг байгалийн баялгаараа дэлхийд тэргүүлж байна.

Үүнээс гадна Монгол Улс малын бэлчээрээр дэлхийн тэргүүний эгнээнд ордог. Ой модны талбай нь 15 сая га бөгөөд ой модны хэмжээ, ойн талбайгаараа ч дэлхийд эхний 15-р байранд ордог юм.

Иймээс Монгол Улс нь тун их алсын сайхан ирээдүйтэй орон бөгөөд бүс нутгийнхаа эдийн засгийн хамтын ажиллагаанд нэлээд чухал байр эзэлдэг юм.

**Гурав.Зүүн хойт Азийн хамтын ажиллагаанд Монгол Улс
хэрхэн оролцох тухай хэдэн зүйлийн эрэгцүүлэл**

**1.Хоёр их хөрш ОХУ, БНХАУ-ыг суурь болгож, ЗХА-ийн улсуудтай
хамтын ажиллагаагаа бүх талаар хөгжүүлэх тухай**

Монгол бол далайд гарцгүй, эх газрын улс тул ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа нь тус улсын хөгжилд чухал ач холбогдолтой юм. Монгол Улс эдийн засгийн хөгжлийн стратеги боловсруулахдаа улс орныхоо өвөрмөц онцлогийг харгалзаж, дээр дурдсан газар зүйн ашигт малтмалын давуу талаа гүйцэд ашиглаж, юуны өмнө хойт, урд хоёр том хөршөө суурь болгож, ЗХА-ийн бүс нутгийн улсуудтай эдийн засаг, техник худалдааны хамтын ажиллагаагаа бүх талаар хөгжүүлж, гадаадын хөрөнгө оруулалт, техник , мэргэжилтний болон удирдлагын туршлагыг сайтар ашиглан, дотоод бололцоогоо дайчлан, олон улсын хөдөлмөрийн хуваарьт идэвхтэй оролцох нь Монгол Улсын эдийн засгийг түргэн хурдацтай хөгжүүлэх гол хөшүүрэг болно.

**2.Хоёр талын болон олон талын эдийн засаг, худалдааны
чөлөөт бүсийн хөгжлийг түргэтгэх тухай**

Монгол улсын Засгийн газраас боловсруулан гаргасан дорнод бүс нутгаа түрүүлж хөгжүүлсний дараа бусад бүс нутгаа хөгжүүлэх стратеги бодлого нь тун зөв, шинжлэх ухааны бүрэн үндэслэлтэй юм. ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд Монгол Улсын дорнод бүс нутаг (Хэнтий, Дорнод, Сүхбаатар) нь газрын байрлалаасаа болж чухал байр эзлэх болно. Уг бүс нутаг нь газар зүйн ба боомтын давуу талаа гүйцэд ашиглан хоёр тал, олон талыг (Монгол, Хятад, Орос гурван улсын хиллэж байгаа уулзвар) улмаар дэлхийн бусад улсуудыг эдийн засгийн чөлөөт бүс байгуулах ажилдаа оролцуулж, хөрөнгө оруулалтын хэмжээгээ нэмэгдүүлж болох юм.

**3.Рашаант-Чойбалсангийн төмөр зам нь Монголын дорнод
бүсийн эдийн засгийг хөгжүүлэх гол судас болох тухай**

Зам тээврийн хөгжил сул байгаа нь Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг чөдөрлөж байгаа гол хүчин зүйлийн нэг мөн. Аливаа улс орны эдийн засаг хөгжих чухал нөхцөл бол зам тээвэр юм. Энэ асуудлыг шийдвэрлэж чадвал сая хөрөнгө мөнгө, дэд бүтэц, боловсон хүчний асуудлыг шийдвэрлэх боломж, нөхцөл, орчин ахуйг бүрэлдүүлж, олон төрлийн ашигт малтмалаа нээн ашиглах хэтийн төлөв нээгдэх болно.

Иймээс Монгол Улс Дорнод бүс нутгаа хөгжүүлэхдээ, юуны өмнө зам тээврээ хөгжүүлбэл зохих бөгөөд мөнгөө төвлөрүүлж, Чойбалсан

хотоос БНХАУ-ын ӨМӨЗО-ы Рашаант боомт хүртэл төмөр зам хурдхан тавибал ашигтай. Энэ хэсэг төмөр зам бол Ази Европыг холбосон их гүүрийн нэг хэсэг байх болно. Хэрвээ энэ зам тавигдвал Монголын дорнод бүс нутаг “Түмэн голын” нээлттэй бүстэй шууд холбогдоно. Улмаар Монгол улс далайд гарцтай болж, гадаад хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ашигт малтмалаа ашиглах, дотоод гадаадын жуулчдыг олноор хүлээн авах боломж нээгдэн, Монгол Улсын гадаад валютын орлогыг эрс нэмэгдүүлэх тул тус улсын дорнод бүсийн эдийн засгийн хөгжлийн гол судас болох нь дамжиггүй. Төмөр зам дагаад холбоо, эрчим хүч, авто тээвэр хурдан хөгжиж, нийгмийн асуудлууд ч шийдвэрлэх болно.

4. Нүүрс, цахилгаанаа голлон, ашигт малтмалын давуу талаа гүйцэд ашиглах тухай

Монголын дорнод бүс нутагт холимог металл, нүүрс, уран, давс, хайлуур жонш, газрын тос, үнэт чулуу, гянт болд, хар, цагаан тугалганы арвин орд бий. Холбогдох материалаас үзэхэд Хэнтий аймгийн Бор-өндөр, Хажуу-Улаан, Бэрх, Хөлийн холбоо, Сүхбаатар аймгийн Асгатын хайлуур жонш, Егүзэр, Салаа, Бүрэнцогтын холимог металл, Төмөр -Овоогийн цайр, Дорнод аймгийн Нарсан хөндлөнгийн цагаан тулгалга, Мардай, Нэмрийн уран, Улаан, Цав, Мухар, Баян-уул, Баяндунгийн холимог металл, Тосон уул, Тамсагийн газрын тос, Сангийн далай, Шорвог нуурын давс, шүү, Булангийн хоолойн нүүрс, Алтан голын шилний элс, Гурван Загалын олон талт цахиур, Халх голын ховор металл, хар тугалга, хүлэр, газрын тос, давс, шүү, барилгын материал, элс зэрэг ашигт малтмалын ордын ихэнхийг одоо болтол олборлоогүй байна.

Түүхий эд бол боловсруулах аж үйлдвэрийн суурь мөн. Япон, БНСУ, БНХАУ зэрэг боловсруулах үйлдвэр хөгжсөн улсуудад түүхий эдийн хэрэгцээ их байдаг. Иймээс Монгол улс давуу байдлаа сайн ашиглаж, гадаадын хөрөнгө оруулж, хамтарсан буюу дангаар хөрөнгө оруулсан аж ахуйн нэгж байгуулах, байгалийн баялгийн давуу байдлаа эдийн засгийн давуу болгон байдал өөрчлөх хэрэгтэй юм.

Монгол Улс Өвөр Монголын туршлагыг авч, нүүрс, цахилгаан эрчим хүчний баялгаа гол болгож, бусад ашигт малтмал, баялгаа нээн ашиглаж чармайлбал сайнсан. Өөрөөр хэлбэл, нүүрсээ цахилгаан болгон (дулааны цахилгаан станц байгуулж) ЗХА-ийн шаардагдах орнуудад “агаараар” буюу өндөр хүчдэлээр дамжуулан хүргэх талаар судалгаа хийж болох юм. Ингэвэл ЗХА-ийн улс орнуудын эдийн засгийн хөгжилд их тус болохоор барахгүй, олон хүнийг ажлын байраар хангах асуудлыг шийдэж, улмаар улс орныхоо үндэсний аж үйлдвэрийг хөгжүүлэхэд шаардагдах эрчим хүчийг бий болгосоноор эдийн засгийн өндөр ашигтай байх болно.

5. Аялал жуулчлалыг хөгжүүлэх тухай

Дэлхийн эдийн засгийн хурдан хөгжлийг дагалдаад “хэлбэр нь үл мэдэгдэх худалдаа” гэгддэг аялал жуулчлал маш хурдан хөгжиж, энэ нь олон орны Засгийн газрын анхаарлын төвд байсаар байна.

Монгол Улс асар их түүх, дурсгалын, үзмэр, онгон тансаг байгальтай, зөвхөн Монголын дорнод хэсэгт гэхэд л дотоод гадаадад алдаршсан Дорнод аймгийн нутагт орших Хэрлэн Барс хотын туурь, их Бурхантын цогцолбор, Чойбалсан хотын ойролцоох харуулын цамхаг, Хэнтий аймгийн нутагт орших Хүннүгийн үеийн язгууртны булш, зураг бичээстэй “Рашаан хад”, Цэцэнханы ордон, Балдан бэрээвэн хийдийн туурь, Чингис хааны амьдралтай холбогдсон газар орон, хөшөө дурсгалууд, Сүхбаатар аймгийн нутагт орших Егүзэр хутагтын хийд, хүн чулуунууд, Хүннүгийн үеийн 200 орчим булш, чулуун хороо шивээ зэрэг шинжлэх ухааны ач холбогдолтой түүхэн дурсгалт газар олон бий.

Гадаадын жуулчдын сонирхол татсан эдгээр ховор нандин баялаг, байгалийн үзэмжит байдал нь ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагааны чухал хэлбэр болох аялал жуулчлалыг Монгол оронд хөгжүүлэх өргөн боломж олгож байна.

Хятад хэлнээс орчуулсан Л.Бэгзжав